



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ын 66.7 хувь нь 2021 оны үйлдвэрлэлийн үр дүнгээр 1,376.9 сая төгрөгийн алдагдал хүлээж, өнөөгийн бүтэц, зохион байгуулалт, менежментээр бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжгүй байдалд хүрсэн байна.

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

АУДИТЫН КОД: СЭА-2022/22-17-ШТА-ГА



Сүхбаатар сум
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа
Утас: 70363040,

Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036,
Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор С.Баасансүрэн
Утас: 70362442

Цахим хаяг: Baasansurens@audit.gov.com
Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.com
Аудитор З.Золбоо

Цахим хаяг: Zolbooz@audit.gov.mn
Аудитор Т.Одсүрэн

Цахим хаяг: Odsuren.t@audit.gov.mn
Аудитор Т.Мөнхзул

Цахим хаяг: Munkhzul.t@audit.gov.mn



Аудитыг гүйцэтгэсэн:
Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор
Ч.Энхтуяа

Аудитын менежер
Б.Батмөнх

Ахлах аудитор
С.Баасансүрэн
Ц.Отгонбаяр

Аудитор
З.Золбоо
Т.Одсүрэн
Т.Мөнхзул

Хаяг: Сэлэнгэ аймаг,
Сүхбаатар сум, аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

2022 оны 05-07 дугаар
сар

АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй байн уу?

1.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн үү?

1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнтэй байна уу?

ХОЁРДУГААР БҮЛЭГ: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай байна уу?

2.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшинг үндэслэлтэй төлөвлөж, хянаж баталсан уу?

2.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн үү?

2.3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилтот түвшнийг хангаж байна уу?

2.4. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж байна уу?

ГУРАВДУГААР БҮЛЭГ: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй байна уу?

3.1. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна уу?

3.2. Дотоод хяналтын тогтолцоо оновчтой, хяналт үр нөлөөтэй байна уу?

3.3. Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж байна уу?

ДҮГНЭЛТ:

ЗӨВЛӨМЖ:

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ-ийн	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨ	Орон нутгийн өмч
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТЭДДҮТТ	Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХЧТА	Хөдөлмөрийн чадвараа түр алдсан
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо

Хүснэгтийн товьёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-уудын судалгаа	7-8
Хүснэгт 2	ОНӨААТҮГ-уудын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө	13
Хүснэгт 3	ОНӨААТҮГ-уудын орлого бүрдүүлэлт	14
Хүснэгт 4	ОНӨААТҮГ-уудын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөний хэрэгжилт	15
Хүснэгт 5	ОНӨААТҮГ-уудын үнэ төлбөргүйгээр олж авсан үндсэн хөрөнгийн элэгдэлд хийсэн шинжилгээ	17
Хүснэгт 6	ОНӨААТҮГ-уудын авлага, өр төлбөрийн судалгаа	18
Хүснэгт 7	ОНӨААТҮГ-уудын санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ	18-19
Хүснэгт 8	ОНӨААТҮГ-уудын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	20
Хүснэгт 9	ОНӨААТҮГ-уудын удирдлагын зардлын хэрэгжилт	21
Хүснэгт 10	ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны хөрөнгө оруулалтын зардал	22

Хавсралтын товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	ОНӨААТҮГ-уудын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	33
Хавсралт 2	ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны гол зардлуудын үнийн судалгаа	34
Хавсралт 3	ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	35
Хавсралт 4	ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны орон тоо, цалингийн зардлын судалгаа	36

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Аудитын зорилго, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.
Аудитын зорилго:	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд асуудлын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ <i>Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх.</i> ➤ <i>Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх.</i> ➤ <i>Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх.</i>
Аудитын хамарсан хүрээ:	Аудитад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн ТУЗ-өөс гаргасан тогтоол шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, бусад холбогдох байгууллагын 2019-2021 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МҮЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, бусад шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитад дараах хууль эрх зүйн актыг гол шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд: Хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /1996/

**Аудитын
шалгуур,
үзүүлэлт:**

- Компанийн тухай хууль /2011/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2005/
- Авлигын эсрэг хууль /2006/
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/
- Төсвийн тухай хууль /2011 он/
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /2006, 2021/
- Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/
- Татварын ерөнхий хууль /2019/

Улсын Их Хурлын тогтоол

- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- УИХ-аас гаргасан холбогдох бусад тогтоол.

Засгийн газрын тогтоол

- Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр.”
- Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”.
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”.
- Засгийн газраас гаргасан холбогдох бусад тогтоол, шийдвэрүүд.

Бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд

- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам”.
- Байгууллагын засаглалын олон улсын удирдамж 180 37000 стандарт.
- Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас гаргасан Компанийн засаглалын зарчмууд.
- УСНББОУС, НББОУС болон бусад стандартууд.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа:**

- Татварын ерөнхий газрын даргын 2017 оны А/06 тушаалаар баталсан “Татвар төлөгчийг бүртгэх журам”.
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор С.Баасансүрэн, Ц.Отгонбаяр, аудитор З.Золбоо, Т.Одсүрэн, Т.Мөнхзул нар 2022 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн хооронд гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

2021 оны байдлаар аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 24 ОНӨААТҮГ, 6 орон нутгийн өмчийн оролцоотой ХХК-ийг байгуулсан байна.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудыг үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл:

- ААНБ, айл өрхийг дулааны эрчим хүчээр хангах чиглэлээр 3,
- ААНБ, айл өрхийг цэвэр усаар хангах, ахуйн болон технологийн бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх 3,
- Хот тохижилт 7,
- Сувилал 2,
- Бусад чиглэлээр 9 байна.

Эдгээрээс 18 нь тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байгаа бол ТЭДДҮТТ /Тариалан эрхлэлтийг дэмжих дундын үйлчилгээний техникийн төв/, “Сэлэнгэ баялаг ирээдүй”, “Мандал хишиг хайрхан”, “Мандах зэлтэр тохижилт үйлчилгээ”, “Хушаат дуут хад”, “Баянгол хөгжлийн гүүр” зэрэг 6 ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаа тогтворжоогүй байна.

Дээрх ОНӨААТҮГ-уудаас аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор үүсгэн байгуулагдсан дулаан үйлдвэрлэх, түгээх, усан хангамж, ариутгах, татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 6 ОНӨААТҮГ-ыг аудитад хамруулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэл, үүсгэн байгуулсан шийдвэрийн мэдээллийг хүснэгтээр харуулбал:

Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-уудын судалгаа

Хүснэгт №1

Д/д	ОНӨААТҮГ-ын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Үүсгэн байгуулагдсан шийдвэр	Нэмэлт өөрчлөлт оруулсан эсэх
1	Сэлэнгэ Энерго	Дулаан үйлдвэрлэх, хангах, түгээх	Аймгийн ИТХ-ын 2000.07.21-ний өдрийн 60 дугаар тогтоолоор ОНӨААТҮГ-ыг байгуулсан.	
2	Мандал Энерго	Дулаан үйлдвэрлэх, түгээх, хэрэглээний цэвэр ус дамжуулан түгээх	Мандал сумын ИТХ-ын 2013.12.20-ны өдрийн 45 дугаар тогтоолоор “Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ-ыг байгуулсан.	Мандал сумын ИТХТ-ийн 2020.04.17-ны өдрийн 17 дугаар тогтоолоор “Мандал Энерго” ОНӨААТҮГ болгож, нэрийг өөрчилсөн.
3	Туулын хишиг	Дулаан үйлдвэрлэх, хангах, түгээх, газар тариалан эрхлэх	Орхонтуул сумын ИТХТ-ийн 2009.04.24-ний өдрийн 28 дугаар тогтоол	
4	Сэлэнгэ цэнгэг ус	Усны хайгуул судалгаа, Ус хангамж ариутгах татуурга, Ус цэгийн засвар, өрөмдлөгийн ажил	Аймгийн ИТХТ-ийн 2005.10.25-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Урсгал ус” орон нутгийн өмчит ХХК-ийг байгуулсан.	Аймгийн ИТХ-ын 2021.07.02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Сэлэнгэ цэнгэг ус” ОНӨААТҮГ болгож, бүтэц, зохион байгуулалтыг өөрчилсөн.
5	Гавшгай ус	Ус хангамж цэвэрлэх байгууламж, зочид буудлын үйлчилгээ, хотын доторх инженерийн шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийх, Номгон тосгоны уурын зуух ажиллуулах	Аймгийн ИТХТ-ийн 2005.10.25-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Хөтөл” орон нутгийн өмчит ХХК-ийг байгуулсан.	Аймгийн ИТХ-ын 2006.09.05-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор “Гавшгай Ус” ХХК, 2021.07.02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Гавшгай Ус” ОНӨААТҮГ болгож, бүтэц зохион байгуулалтыг өөрчилсөн.
6	Цант-Орхон	Усан хангамж, ариутгах татуурга, халуун ус	Аймгийн ИТХТ-ийн 2005.10.25-ны өдрийн 78 дугаар тогтоолоор “Цант-Орхон” орон нутгийн өмчит ХХК-ийг байгуулсан.	Аймгийн ИТХ-ын 2021.07.02-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор “Цант-Орхон” ОНӨААТҮГ болгож, бүтэц, зохион байгуулалтыг өөрчилсөн.

Эх сурвалж: Аймаг, сумдын ИТХ-ын тогтоол.

Аймгийн ИТХТ-ийн 2017 оны 73, 107, 108 дугаар тогтоолуудаар Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулах, орон нутгийн өмчийн оролцоотой “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК, “Сэлэнгэ хаш баялаг” ХХК, “Сэлэнгэ ресурс” ХХК-ийг байгуулсан байна.

Баянгол сумын ИТХ-ын 2017 оны 26, 44 дүгээр тогтоолуудаар газар тариалан, ашигт малтмалын хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Баян хишиг хараа” ХХК, “Өгөөмөр баян ундарга” ХХК, Мандал сумын ИТХТ-ийн 2017 оны 106 дугаар тогтоолоор газар тариалан, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулах “Хараа хамтын ажиллагаа” зэрэг орон нутгийн өмчийн оролцоотой компаниудыг тус тус байгуулсан байна.

Орон нутгийн өмчийн оролцоотой дээрх 6 компани нь тогтвортой үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан боловч Улаанбаатар-Дархан чиглэлийн засварын ажлаас шалтгаалан үйл ажиллагаа явуулаагүй байна.

Бүлэг 1

• Аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт компани / ОНӨААТҮГ/-ийн засаглалыг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр үр нөлөө бүхий арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлээгүй байна.

1.1 ОНӨААТҮГ-ын оролцогч талуудын зохистой харьцааг тогтоосон эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

1.1.1 Компанийн засаглал нь компанийг үр дүнтэй удирдах, үйл ажиллагааг нь зөв зохион байгуулахад чиглэсэн олон талт үйл ажиллагааг хамарсан ойлголт бөгөөд компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг, сонирхлын зохистой харьцааг тогтоодог тогтолцоо юм.

1.1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанид төрийн болон орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулж байгаа бол Компанийн тухай хуулиар компанийн засаглалтай холбогдох дараах харилцааг зохицуулж байна. Үүнд:

- ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох,
- Гүйцэтгэх удирдлагыг томилох,
- ТУЗ-ийн дэргэдэх хороо, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдсон харилцаа,
- Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагаа гэх мэт.

1.1.3 Өөрөөр хэлбэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хувьчлах, тэдгээртэй холбогдох төрийн байгууллагуудын бүрэн эрх, үүрэг зэрэг эд хөрөнгийн эрхтэй холбогдох харилцааг голчлон зохицуулсан байдаг бол компанийн засаглалтай холбогдох үйл ажиллагааг Компанийн тухай хуулиар зохицуулж байна.

1.1.4 Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” болон Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Компанийн засаглалын кодекс” буюу компанийн удирдлага, зохион байгуулалтын зарчмууд хувьцаа нь нийтэд чөлөөтэй арилжаалагддаг, нээлттэй буюу хаалттай хувьцаат компанид тухайлан зориулж боловсруулагдсан бөгөөд бусад хуулийн этгээдийн тухайд өөрийн онцлогт тохируулан хэрэглэх боломжтой байна.

1.1.5 Дээрх хууль, эрх зүйн актын зохицуулалтаас харахад орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын оролцогч талуудын зохистой харьцааг тогтоосон хууль, эрх зүйн актууд хангалтгүй байна.

1.1.6 Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг дагаж мөрдүүлэх, Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх, засаглалын түвшинг сайжруулах, компанид засаглалын хөндлөнгийн үнэлгээ хийх, түвшинг тогтоох, тайлагнах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор “Компанид засаглалын үнэлгээ хийх, түшин тогтоох журам”-ыг баталсан байна.

1.1.7 Уг журмын 3 дугаар зүйлийн 3.2.1-д “Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компани засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болох”-оор заасан байна.

1.1.8 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.1¹, 77.2.4²-т заасны дагуу аймаг, сумын ИТХ нь орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах болон орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж байгаа боловч үйл ажиллагаанд нь хяналт тавих эрхийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.1.9 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78.2.2 дугаар заалтын дагуу аймаг, сумдын Засаг дарга нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, дарга, удирдлагыг томилон жил бүр гэрээ байгуулж, үнэлэлт дүгнэлт өгч байгаа хэдий ч үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийх, цаашдын бодлого төлөвлөлтийг тодорхойлох, удирдлагаар хангах чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.1.10 Аймгийн ОНӨГ нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх, засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг аймгийн ИТХ, Засаг даргад танилцуулж, шийдвэр гаргуулах чиг үүргийг гүйцэтгэж байна.

1.1.11 Гэвч 2019-2021 онд аймгийн ОНӨГ-аас орон нутгийн өмчит хуулийн этгээдийн орон нутгийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх, засаглалыг сайжруулах, үйл ажиллагаанд хяналт тавьж, үр ашгийг дээшлүүлэх зорилт, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна.

1.1.12 Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд хийсэн “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл, үйл ажиллагааны зохицуулалт, үр ашиг” гүйцэтгэлийн аудитаар аймгийн ОНӨГ-т 3 зөвлөмж өгснөөс ОНӨААТҮГ-ын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаа, ашиг, алдагдал, авлага, өр төлбөрт

¹ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тухайн аймаг, нийслэл, сум дүүргийн өмчийн зүйлсийг хүн амаа төлөөлөн өмчлөгч нь байна.

² Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн хурал дараах бүрэн эрхтэй: 2.4. Орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих.

дүгнэлт өгөх, ОНӨААТҮГ-уудын 3 жилийн хэтийн зорилт, төлөвлөгөөг хянаж, холбогдох байгууллагад хүргүүлэх гэсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

1.2. Аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт компани /ОНӨААТҮГ/-ийн засаглалыг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр үр нөлөө бүхий арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлээгүй байна.

1.2.1 УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн 5.2-т “Эдийн засаг, өмчийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох чиглэлээр” 5.2.1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана.” гэж заасан байдаг.

1.2.2 Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн 1.5.7³ -д заасан зорилтын хүрээнд Урсгал-Ус ХХК, Гавшгай-Ус ХХК, Цант-Орхон ХХК, Сэлэнгэ барилга захиалагч ОНӨААТҮГ, Сэлэнгэ үйлчилгээ ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэж, гүйцэтгэх удирдлагад үүрэг даалгавар өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

1.2.3 УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгох.” гэж заасан байдаг.

1.2.4 Аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор “Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд хөтөлбөрийн 3.6.2⁴ -т заасан зорилтын хүрээнд 2021 онд “Сэлэнгэ Цэнгэг Ус”, “Сэлэнгэ үйлчилгээ”, “Сүхбаатар хөгжилт тохижилт”, “Тохилог хараа”, “Сүхбаатар тохижилт үйлчилгээ” зэрэг 5 ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

1.2.5 Харин ОНӨААТҮГ-уудын оновчтой удирдлагыг хэрэгжүүлээгүйгээс дулаан үйлдвэрлэх, дулааны эрчим хүчээр хангах, усан хангамж, ариутгах татуургын чиг үүрэг хэрэгжүүлж буй томоохон ОНӨААТҮГ-ууд үйл ажиллагаа явуулах тусам алдагдал хүлээж, авлага, өр төлбөрийн хэмжээ буурахгүй, нэмэгдэх чиг хандлагатай байна.

³ Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтад хяналт тавьж, ОНӨ-ийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлнэ.

⁴ ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийж, үйл ажиллагааг сайжруулна.

1.2.6 2021 оны жилийн эцсийн байдлаар аудитад хамрагдсан 6 ОНӨААТҮГ-аас 4 нь үйлдвэрлэлийн үр дүнгээр 1,376.9 сая төгрөгийн алдагдал хүлээж, одоо байгаа бүтэц, зохион байгуулалтаар бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжгүй байдалд хүрсэн байна.

1.2.7 Аудитын түүвэрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдээс “Урсгал-Ус”, “Цант-Орхон”, “Гавшгай-Ус” ХХК-иуд / тухайн үеийн нэршилээр /-ын төлөөлөн удирдах зөвлөл 2019-2021 оны 7 дугаар сар хүртэл үйл ажиллагаагаа явуулж байсан бөгөөд ХХК-ийг ОНӨААТҮГ болгон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийснээр татан буугдсан байна.

1.2.8 Дээрх 3 компанийн ТУЗ нь компанийн тухайн жилийн орлого, зарлагын төлөвлөгөө батлах, санхүүгийн тайланг үнэлж дүгнэх, цалин, урамшуулал, буцалтгүй тусламж олгох, хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой шийдвэрүүдийг гаргаж байсан нь засаглалыг хөгжүүлэхэд төдийлөн үр нөлөө үзүүлж чадаагүй байна.



Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-уудын 66.7 хувь нь 2021 оны үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээсэн байна.

2.1 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд зорилтот түвшинг байгууллагын 3 жилийн хэтийн зорилттой уялдуулж төлөвлөөгүй, аймгийн ОНӨГ-аар хянуулж, дүгнэлт гаргуулаагүй байна.

2.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т ОНӨААТҮГ-ууд 3 жилийн хэтийн зорилтын саналыг боловсруулах, түүнийг хянаж, нэгтгэх, талаар зохицуулагдсан атал хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- ОНӨААТҮГ-ууд жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор 3 жилийн хэтийн зорилт, үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ, санхүүгийн төлөв, төлөвлөж байгаа ашиг, төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг, төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт зэргийг тусгасан зорилтын саналын төслийг аймгийн ОНӨГ-т хүргүүлээгүй,
- ОНӨГ нь зорилтын саналыг хянаж, нэгтгээгүйгээс саналыг дүгнэлтийн хамт Сангийн яаманд жил бүрийн 03 дугаар сарын 15-ны дотор хүргүүлээгүй,
- ОНӨААТҮГ-ын удирдлага нь ОНӨГ-тай тухайн хуулийн этгээдийн зорилтын саналын талаар жил бүрийн 03 дугаар сарын 25-ны дотор тохиролцоогүй байна.

2.1.2 Харин дээрх хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3⁵-д заасны дагуу аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ууд нь өмнөх жилүүдийн орлого, зарлагын гүйцэтгэл, эрх

⁵ Захирал дараахь эрх, үүрэгтэй: 3/ үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах.

бүхий байгууллагаас батлагдсан үнэ тариф, бүтэц орон тоонд суурилан санхүүгийн төлөв, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөгөө дараах байдлаар тодорхойлж, “Сэлэнгэ Энерго”-оос бусад үйлдвэрийн газрууд нь эрх бүхий байгууллагаар батлуулсан байна.

ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө

Хүснэгт №2

/сая төгрөг/

Д-д	ОНӨААТҮГ-ын нэр	2019 он			2020 он			2021 он		
		Орлого	Зарлага	Ашиг/алдагдал	Орлого	Зарлага	Ашиг/алдагдал	Орлого	Зарлага	Ашиг/алдагдал
1	Сэлэнгэ цэнгэг ус	1,657.1	1,653.6	3.5	1,953.7	2,415.3	(461.6)	2,647.2	2,761.4	(114.2)
2	Гавшгай ус	1,590.8	1,580.8	10.0	1,223.8	2,350.5	(1,126.7)	1266.2	1889.7	(623.5)
3	Цант-Орхон	729.8	727.6	2.2	851.9	1,155.3	(303.4)	826.50	1,153.0	(326.5)
4	Сэлэнгэ Энерго	5,786.4	7,590.1	(1,803.7)	5,721.9	7,378.3	(1,656.4)	5844.4	7506.7	(1,662.3)
5	Мандал Энерго	967.6	955.7	11.9	908.6	977.9	(69.3)	930.9	917	13.90
6	Туулын хишиг	239.8	232.2	7.6	276.4	273.1	3.3	281.5	279.8	1.70

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны эдийн засгийн зорилтот түвшин.

2.1.3 Хүснэгтээс харахад “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ нь жил бүр, Сэлэнгэ цэнгэг ус, Гавшгай ус, Цант-Орхон зэрэг ОНӨААТҮГ-нь 2020-2021 онуудад тус тус алдагдалтай ажиллахаар төлөвлөсөн бөгөөд энэ нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой элэгдлийн зардал нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

2.1.4 Мандал Энерго ОНӨААТҮГ нь 2020 онд санхүүжүүлэх эх үүсвэр нь тодорхойгүйгээр 69.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөсөн байна.

2.1.5 Аудитад хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь байгууллагын хэтийн зорилт, үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ, санхүүгийн төлөв, төлөвлөж буй ашиг, хөрөнгө оруулалт зэргийг орон нутгийн бодлого шийдвэрт нийцүүлэн дунд хугацаанд төлөвлөж, төрийн байгууллагаар хянуулах үйл ажиллагаа хийгдэхгүй байна.

2.2 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2019-2021 онуудын орлогын төлөвлөгөө 90.9-110.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

2.2.1 Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ууд 2019 онд төлөвлөсөн орлогын 90.9 хувь буюу 9,977.6 сая төгрөг, 2020 онд 95.5 хувь буюу 10,442.7 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн бол 2021 онд 13,079.4 сая төгрөгийн орлого бүрдүүлснээр орлогын төлөвлөгөө 110.9 хувьтай тайлагнагдсан байна. / Хавсралт 1-д дэлгэрэнгүйгээр харуулав /

2.2.2 Засгийн газрын 2020 оны 211 дүгээр “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 1-д “Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн

нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр ... хураамжийг 2020.12.1-ний өдрөөс тооцож 2021.12.31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх” гэсэн заалтын хэрэгжилттэй холбоотойгоор ОНӨААТҮГ-ын дүнгээр 2021 онд орлогын төлөвлөгөө 10.9 хувиар давж биелсэн байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, үйлчилгээний төлбөрийг тухай бүр барагдуулж ажиллавал төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэх боломжтой байгаа нь харагдаж байна.

2.2.3 Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Татвар төлөгч холбогдох татварын хуулиар төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлж, хуулиар тогтоосон хугацаанд төсөвт төлнө” гэж заасан байдаг.

2.2.4 Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ууд нь тайлант онуудад Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Татварын ерөнхий хуульд зааснаар улс, орон нутгийн төсөвт 3,682.1 сая төгрөгийн татвар, төлбөр, хураамжийг төвлөрүүлэхээр тайлагнаж, 72.3 хувь буюу 2,661.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ОНӨААТҮГ-уудын орлого бүрдүүлэлт

Хүснэгт №3

/сая төгрөг/

ОНӨААТҮГ-ын нэр	Үзүүлэлт	ААНОАТ	НӨАТ	ХХОАТ	ҮХХАТ	АТБӨЯХАТ	Газрын төлбөр
Мандал Энерго	Ногдуулсан	7.40	250.80	51.20	0.60	0.80	0.06
	Төлсөн	5.80	256.90	52.70	0.60	1.10	0.06
Туулын хишиг	Ногдуулсан	12.36	55.67	16.96	0.16	-	0.99
	Төлсөн	4.79	50.47	15.50	0.16	-	0.72
Гавшгай ус	Ногдуулсан	-	254.92	106.36	12.33	0.57	0.59
	Төлсөн	2.00	328.55	92.39	15.06	2.85	0.38
Сэлэнгэ Энерго	Ногдуулсан	-	1,727.60	411.30	28.00	2.70	0.90
	Төлсөн	-	1,148.60	66.80	1.00	2.70	0.90
Цант-Орхон	Ногдуулсан	0.57	249.72	68.60	4.75	1.53	2.19
	Төлсөн	0.57	262.77	68.60	4.75	1.53	2.19
Сэлэнгэ цэнгэг ус	Ногдуулсан	-	248.06	140.01	18.73	1.13	4.55
	Төлсөн	0.67	200.04	55.04	8.94	1.33	5.38
Нийт дүн	Ногдол	20.33	2,786.77	794.43	64.58	6.73	9.28
	Төлсөн	13.83	2,247.33	351.02	30.51	9.51	9.64

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны жилийн эцсийн татварын тайлан

2.2.5 ОНӨААТҮГ-уудын улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нийт орлогын 75.7 хувийг НӨАТ, 21.6 хувийг ХХОАТ, 2.8 хувийг бусад татвар, төлбөр, хураамж эзэлж байна. Тайланд онуудад улсын төсөвт НӨАТ 2,247.3 сая төгрөг, ААНОАТ /60 хувь/ 8.2 сая төгрөг, аймгийн төсөвт ААНОАТ /40 хувь/ 8.2 сая төгрөг, АТБӨЯХАТ 9.5 сая төгрөг, сумын төсөвт ХХАОТ 351.0 сая төгрөг, ҮХХАТ 30.5 сая төгрөг, газрын төлбөр 9.6 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2.2.6 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ, “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ-ууд нь хамгийн бага буюу төлбөл зохих татвар, төлбөр хураамжийнхаа 56.8-65.2 хувийг төвлөрүүлсэн байна.

2.3 Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ууд нь үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээхээр зорилтот түвшинг тодорхойлсон бөгөөд 66.7 хувь нь 2021 онд 1,376.9 сая төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

2.3.1 Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ууд нь жил бүр санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг тооцож байгаа боловч ашгийг хамгийн их, зардлыг хамгийн бага байлгах тооцоо шинжилгээ хийгээгүй, үр нөлөөг үнэлж ажиллаагүй байна.

2.3.2 Бид аудитын явцад аудитын түүвэрт хамрагдсан үйлдвэрийн газруудын эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэлд үндэслэн санхүүгийн үйл ажиллагааны үр ашигт нөлөөлж буй хүчин зүйлүүдийг судалж, үр нөлөөг тооцоход дараах байдалтай байна.

ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөний хэрэгжилт

Хүснэгт №4

/сая төгрөг/

Д/д	ОНӨААТҮГ-ын нэр	2019 он			2020 он			2021 он		
		Орлого	Зарлага	Ашиг/ алдагдал	Орлого	Зарлага	Ашиг/ алдагдал	Орлого	Зарлага	Ашиг/ алдагдал
1	Сэлэнгэ цэнгэг ус	1,306.4	1,899.8	(593.5)	1,339.6	2,100.7	(761.0)	2,468.4	2,553.8	(85.4)
2	Гавшгай ус	1,518.9	2,098.6	(579.7)	1,548.8	2,014.2	(465.4)	1,441.2	1,693.9	(252.7)
3	Цант-Орхон	746.4	1,148.4	(402.0)	825.8	1,114.4	(288.6)	912.2	1,153.2	(241.0)
4	Сэлэнгэ Энерго	5,344.9	7,256.1	(1,911.2)	5,685.1	7,160.4	(1,475.3)	6,869.8	7,667.6	(797.8)
5	Мандал Энерго	852.4	848.2	4.2	820.6	889.0	(68.4)	1,000.4	961	39.4
6	Туулын хишиг	208.7	205.1	3.6	222.7	269.1	(46.4)	387.3	269.1	118.2

Эх сурвалж: ОНӨААТҮГ-ууын эдийн засгийн зорилтот түвшин.

2.3.3 Аудитад хамрагдсан үйлдвэрийн газруудын 2019 онд 66.7 хувь нь, 2020 онд 100 хувь, 2021 онд 66.7 хувь нь үйл ажиллагааны үр дүнгээр алдагдал хүлээхээр зорилтот түвшнээ тодорхойлсон байна.

2.3.4 Туулын хишиг, Мандал Энерго ОНӨААТҮГ нь 2019, 2021 онуудад үйлдвэрлэлийн үр дүнгээр ашиг хүртсэн бол бусад үйлдвэрийн газрууд 2019-2021 онд алдагдалтайгаар тайлагнагдсан байна.

2.3.5 Үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээхэд дараах хүчин зүйлүүд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна. Үүнд:

- Үйлдвэрийн гол зардлуудын үнийн өсөлт,
- Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалсан элэгдлийн зардлын өсөлт,
- Улс, орон нутгийн төсөв, хандив, буцалтгүй тусламжаар бий болсон үндсэн хөрөнгийн бүртгэлийн арга гэх мэт.

2.3.6 Аудитын явцад үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны зардалд голлон нөлөөлж буй хэд хэдэн төрлийн зардлын 2019-2021 оны үнийн өөрчлөлтийн судалгааг хийж үзэхэд нэг тонн нүүрсний үнэ 50.3 хувиар, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 31.3 хувиар, цахилгааны үнэ 17.1 хувиар, шатахууны үнэ литр тутамдаа 21.9-31.4 хувиар, гадаад валютын ханш 4.2-14.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. / Хавсралт 2-т дэлгэрэнгүй харуулав./

2.3.7 Сэлэнгэ цэнгэг ус, Гавшгай ус, Цант-Орхон, Сэлэнгэ Энерго зэрэг ОНӨААТҮГ-уудын алдагдалд дараах хүчин зүйлүүд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үр дүнгээр их хэмжээний алдагдал хүлээж буй Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ нь Сүхбаатар, Алтанбулаг, Цагааннуур, Ерөө сумын Бугант тосгоны айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг дулааны эрчим хүчээр хангадаг бөгөөд 2020 онд Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан дулааны үнэ тарифыг бус 2015 онд баталсан үнэ, тарифыг мөрдөж байгаагаас жил бүр алдагдлын хэмжээ өссөн байна. Гэтэл дээрх хугацаанд үйлдвэрлэлийн гол зардлууд 17-50.3 хувиар өссөн байна.
- Цант-Орхон ОНӨААТҮГ-ын алдагдалд элэгдлийн зардал голлон нөлөөлсөн бол Сэлэнгэ цэнгэг ус, Гавшгай ус зэрэг үйлдвэрийн газрын алдагдалд элэгдлийн зардлаас гадна үйлдвэрлэлийн гол зардлуудын үнийн өсөлт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.

2.3.8 НББОУС 20⁶-д улс, орон нутгийн төсөв, хандив, буцалтгүй тусламжаар бий болсон үндсэн хөрөнгийг бүртгэхдээ нягтлан бодох бүртгэлийн 2⁷ нийтлэг аргыг ашиглахаар заасан бөгөөд аудитад хамрагдсан үйлдвэрийн газрууд нь дээрх эх үүсвэрээс бий болсон үндсэн хөрөнгийг капиталын аргаар бүртгэснээс элэгдлийн зардал өсөж, алдагдал нэмэгдсэн байна.

2.3.9 Тухайлбал үйлдвэрийн газрууд нь аудитад хамрагдсан 2019-2021 онуудад улс, орон нутгийн төсөв, хандив, буцалтгүй тусламжаар 405.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авч, эдгээрт 79.3 сая төгрөгийн элэгдлийн зардал хуримтлуулж бүртгэсэн байна.

ОНӨААТҮГ-уудын үнэ төлбөргүйгээр олж авсан үндсэн хөрөнгийн элэгдэлд хийсэн шинжилгээ

Хүснэгт №5

/сая төгрөг/

Д/д	ОНӨААТҮГ-ын нэр	Он	Үндсэн хөрөнгийн	
			Анхны өртөг	Элэгдэл
1	Мандал Энерго	2020	130.9	18.00
2	Сэлэнгэ Энерго	2019	34.17	5.13

⁶ НББОУС 20 - Засгийн газрын буцалтгүй тусламжийн бүртгэл болон Засгийн газрын тусалцааны тодруулга

⁷ 1.Капиталын арга: нь буцалтгүй тусламж, үнэ төлбөргүй хөрөнгийг ашиг алдагдлаас гадуур, шууд эзэмшигчдийн хувь оролцооны өсөлт байдлаар бүртгэх.

2. Орлогын арга: нь буцалтгүй тусламж, үнэ төлбөргүй хөрөнгийг нэг ба түүнээс дээш тайлант үеүдэд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэх.

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг

		2020	30.00	3.00
		2021	100.11	5.01
3	Туулын хишиг	2019	2.69	0.81
		2020	30.00	10.00
4	Гавшгай ус	2019	17.90	5.40
5	Сэлэнгэ цэнгэг ус	2019	47.10	28.20
		2020	13.00	3.80
Нийт дүн			405.87	79.34

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан.

2.3.10 Үнэ төлбөргүйгээр олж авсан үндсэн хөрөнгийг орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь **орлогын арга** буюу нэгээс дээш тайлант үеүдэд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэх нь тохиромжтой юм.

2.3.11 Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-уудын авлага, өр төлбөрийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

ОНӨААТҮГ-уудын авлага, өр төлбөрийн судалгаа

Хүснэгт №6

/сая төгрөг/

Д/д	ОНӨААТҮГ-ын нэр	Авлага			Өр төлбөр		
		2019 он	2020 он	2021 он	2019 он	2020 он	2021 он
1	Сэлэнгэ цэнгэг ус	1202.61	1,384.1	1,849.2	1,324.36	1,627.9	1,714.8
2	Мандал Энерго	48.8	59.1	81.1	63.10	94.3	64.7
3	Сэлэнгэ Энерго	836.2	1,161.9	1,629.8	5,978.10	7,221.2	7,997.2
4	Туулын хишиг	87	84.5	76.8	178.90	197.8	85.0
5	Гавшгай-Ус	1464.4	1,544.3	1,315.2	1,780.30	1,970.2	1,733.1
6	Цант-Орхон	36.6	54.5	89.2	26.20	1.6	5.1
Нийт дүн		3,675.6	4,288.4	5,041.3	9,351.0	11,113.0	11,599.9

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан.

2.3.12 ОНӨААТҮГ-уудын авлага, өр төлбөрийн өсөлт, бууралтад дүн шинжилгээ хийж үзэхэд төрөөс хариуцах ус, дулааны төлбөрийг / 2021 оны / 2022 онд барагдуулсантай холбоотой ихэнх үйлдвэрийн газруудын авлага, өр төлбөр өссөнөөс гадна дараах хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ нь ЭХЗЗ-өөс гаргасан шийдвэрийн дагуу 2021 онд цалингийн зардлыг 25 хувиар, Сэлэнгэ цэнгэг ус ААТҮГ нь цалингийн зардлыг 23-90 хувиар нэмэгдүүлсэн холбоотойгоор ХХОАТ, НДШ-ийн өр, төлбөр нэмэгдсэн,
- Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2021 онд өөрийн эзэмшлийн тариалангийн талбайг бусдад түрээслүүлснээс шалтгаалан орлого нэмэгдэж, өр төлбөр 85.0 сая төгрөгөөр буурсан байна.

2.3.13 Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар баталсан ААНБ-ын “Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн аргачлал” болон “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн болон эрсдэлийн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу ОНӨААТҮГ-

уудын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд шинжилгээ хийж, эрсдэлийн түвшин өндөр гарсан үзүүлэлтүүдийг авч үзэхэд дараах байдалтай байна.

ОНӨААТҮГ-уудын санхүүгийн тайланд хийсэн шинжилгээ

Хүснэгт №7

/ сая төгрөг/

№	ОНӨААТҮГ-ын нэр	Авлагын эргэц /удаа/	Эргэлтийн харьцаа	Борлуулалтын өгөөж
	Зохих түвшин	5.0-10.0	>1.5-2.0	>0.1-0.2
1	Сэлэнгэ Энерго	4.40	0.30	(0.13)
2	Мандал Энерго	14.10	2.40	(0.04)
3	Туулын хишиг	4.73	1.37	0.31
4	Сэлэнгэ цэнгэг ус	1.51	1.26	(0.03)
5	Гавшгай ус	1.00	0.95	(0.18)
6	Цант-Орхон	12.58	88.90	(0.27)

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын 2021 оны санхүүгийн тайлангийн шинжилгээ.

2.3.14 Сэлэнгэ Энерго, Сэлэнгэ цэнгэг ус, Гавшгай ус зэрэг ОНӨААТҮГ-ууд нь хуримтлагдсан авлага ихтэй, авлага цуглуулах менежмент сул, богино хугацаат өр төлбөрийг төлөх эргэлтийн хөрөнгө хүрэлцэхгүй, төлбөр гүйцэтгэх чадвар сул, борлуулалтын орлогын нэгж тутмаас 3-18 мөнгөний алдагдал хүлээж байна.

2.3.15 Өөрөөр хэлбэл цэвэр ус нийлүүлж, бохир усыг татан зайлуулах, халаалт дулаан нийлүүлэх зэрэг стратегийн ач холбогдол бүхий чиг үүргийг хэрэгжүүлж буй Сэлэнгэ Энерго, Сэлэнгэ цэнгэг ус, Гавшгай ус зэрэг томоохон ОНӨААТҮГ-ууд нь одоо байгаа бүтэц зохион байгуулалт, менежментээр үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн, ашигтай ажиллаж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй нөхцөл байдалд хүрсэн байна.

2.3.16 Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ууд нь 2019-2021 онд их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий гэрээ, хэлцэл байгуулаагүй байна.

2.4 Дийлэнх ОНӨААТҮГ-ууд нь удирдлагын зардлыг бодитоор төлөвлөхгүй байна.

2.4.1 Аудитад хамрагдсан орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд 2019-2021 онд нийт зардлыг 41,798.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 41,302.7 сая төгрөг зарцуулсан байна.

ОНӨААТҮГ-уудын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт №8

/сая төгрөг/

Д.д	ОНӨААТҮГ-ын нэр	Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он
1	Сэлэнгэ цэнгэг ус	Төлөвлөгөө	1,653.6	2,415.3	2,761.5
		Гүйцэтгэл	1,899.9	2,100.7	2,553.8
		Гүйцэтгэлийн хувь	114.9	87.0	92.5
2	Гавшгай ус	Төлөвлөгөө	1,580.8	2,350.5	1,889.7
		Гүйцэтгэл	2,098.6	2,014.2	1,693.9

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг

		Гүйцэтгэлийн хувь	132.8	85.7	89.6
3	Цант-Орхон	Төлөвлөгөө	727.6	1,155.3	1,153.0
		Гүйцэтгэл	1,148.4	1,114.4	1,153.2
		Гүйцэтгэлийн хувь	157.8	96.5	100.0
4	Сэлэнгэ Энержо	Төлөвлөгөө	7,590.1	7,378.3	7,506.7
		Гүйцэтгэл	7,256.1	7,160.4	7,667.6
		Гүйцэтгэлийн хувь	95.6	97.0	102.1
5	Мандал Энержо	Төлөвлөгөө	955.7	977.9	917.0
		Гүйцэтгэл	848.2	889.0	961.0
		Гүйцэтгэлийн хувь	88.8	90.9	104.8
6	Туулын хишиг	Төлөвлөгөө	232.2	273.1	279.8
		Гүйцэтгэл	205.1	269.1	269.1
		Гүйцэтгэлийн хувь	88.3	98.5	96.2
Нийт дүн		Төлөвлөгөө	12,740.01	14,550.41	14,507.67
		Гүйцэтгэл	13,456.27	13,547.80	14,298.63
		Гүйцэтгэлийн хувь	105.6	93.1	98.6

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

2.4.2 Хүснэгтээс харахад 2019 онд нийт зардлыг Гавшгай ус ААТҮГ нь 32.8 хувь буюу 517.8 сая төгрөгөөр, Цант-Орхон ААТҮГ нь 57.8 хувь буюу 420.8 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байгаа нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой элэгдлийн зардлыг дутуу төлөвлөсөн, уг зардал өссөнөөс шалтгаалсан байна.

2.4.3 Аудитаар аудитын түүвэрт хамрагдсан 6 орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2019-2021 оны үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Нэг. Шууд худалдан авах босго үнээс давсан худалдан авалтыг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн. Үүнд:

- Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ нь 2021 онд 125.8 сая төгрөгийн нүүрс,
- Сэлэнгэ цэнгэг ус ОНӨААТҮГ нь 2021 онд 72.0 сая төгрөгийн шатахуун, 76.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө,
- Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2021 онд нүүрс тээвэрлэх үйлчилгээ 42.5 сая төгрөг.

Хоёр. Гавшгай ус ААТҮГ нь:

- Бараа материалын үлдээглээр тайлагнагдсан 40.9 сая төгрөгийн өртөг бүхий насос, хөдөлгүүр нь хүчин чадал тохирохгүйгээс ашиглах боломжгүй болсон.

Гурав. Сэлэнгэ цэнгэг ус ААТҮГ нь:

- ХЧТА болон жирэмсэн, амаржсаны тэтгэмжийн тооцоог НДХ-ээр хянаж баталгаажуулаагүй байхад авлага үүсгэж, бүртгээсэн 5.6 сая төгрөг,
- Албан байгууллагаас авах 92.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, айл өрхөөс авахаар тайлагнасан 26.9 сая төгрөгийн хариуцагч тодорхой бус.
- Холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр цалин хөлсийг 23.0-90.0 хувиар нэмээдүүлж, 117.1 сая төгрөг олгосон.

Дөрөв.Туулын хишиг ОНӨААТҮГ нь:

- Агуулахын бүртгэл хөтлөөгүй, өдөрт зарцуулах нүүрсний норм, нормативыг тогтоогоогүй, шаардах хуудсыг бичсэн, олгосон, хянасан албан тушаалтны гарын үсэггүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нүүрс олгосон 35.8 сая төгрөг, / 2021 он /
- Төсвийн байгууллагаас авах авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 38.2 сая төгрөг, / 2021 он /
- 2021 онд ажил гүйцэтгэх гэрээг дүгнээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нүүрс тээврээр ажлын хөлсөнд 16.8 сая төгрөг олгосон.

Цант-Орхон ААТҮГ :

- ХХОАТ чөлөөлөгдөх орлогоос буюу хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын цалингаас 2.9 сая төгрөг ХХОАТ суутгасан.

2.4.4 Дээрх зөрчлүүдээс гадна Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрч, акт, албан шаардлага бичигдэж, зөвлөмж өгөгдсөн байна. / Хавсралт 3-т дэлгэрэнгүй харуулав./ Үүнд:

- Цалин, нэмэгдэл, урамшил, тэтгэмжийг алдаатай тооцоолсон, тушаал шийдвэрлүүлж буюу давхардуулан олгосон 13.8 сая төгрөг,
- Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журам зөрчсөн 1,075.5 сая төгрөг,
- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэсэн 21.6 сая төгрөг,
- Цалин, урамшууллыг нийгмийн даатгал, татварын тайланд зөрүүтэй тайлагнасан 16.5 сая төгрөг,
- Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, дутуу тусгасан 283.3 сая төгрөг,
- Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгдээгүй 221.0 сая төгрөг,
- Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр зээл авсан 15.4 сая төгрөг,
- Үйлдвэрлэлд тухай бүр ашиглагдахгүй бараа материалыг жил бүр их хэмжээгээр худалдан авч нөөцлөн, хөрөнгийн эргэлтийг удаашруулсан 10.0 сая төгрөг,
- Бусдад хандив өгсөн 0.3 сая төгрөг.

2.4.5 Аудитад хамрагдсан орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь 2019-2021 онд удирдлагын зардлыг 2,368.6 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 57.4 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар хэтрүүлэн зарцуулсан байна.

ОНӨААТҮГ-уудын удирдлагын зардлын хэрэгжилт

Хүснэгт №9

/сая төгрөг/

Д.д	ОНӨААТҮГ-ын нэр	2019 он			2020 он			2021 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
1	Сэлэнгэ цэнгэг ус	321.2	105.8	32.9	381.5	83.5	21.9	488.8	93.5	19.1
2	Мандал Энерго	229.7	90.6	39.4	109.3	106.9	97.8	113.8	115.7	101.7
3	Сэлэнгэ Энерго	132.2	407.0	307.9	114.8	398.6	347.2	138.4	482.7	348.8
4	Туулын хишиг	9.7	46.5	479.4	10.6	37.3	351.9	9.6	39.5	411.5
5	"Гавшгай ус	81.0	75.4	93.1	94.4	185.6	196.6	31.1	60.3	193.9
6	Цант-Орхон	42.4	41.7	98.3	30.3	28.7	94.7	29.8	26.8	89.9
	Нийт дүн	816.2	767.0	94.0	740.9	840.6	113.4	811.5	818.5	100.9

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

2.4.6 Хүснэгтээс харахад Мандал Энерго, Гавшгай ус, Цант-Орхон ОНӨААТҮГ нь удирдлагын зардлыг жил бүр бодитоор төлөвлөж байгаа бол Сэлэнгэ цэнгэг ус ОНӨААТҮГ нь хэт өндрөөр (19.1-32.9) хувиар илүү, Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ нь 3 дахин бага, Туулын хишиг ОНӨААТҮГ нь 3.5-4.8 дахин бага хувиар буюу бодит гүйцэтгэлээс хэт багаар төлөвлөж байна.

2.4.7 Аудитаар удирдлагын зардлын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Цант-Орхон ХХК нь хуралд оролцсон хурлын тэмдэглэл, ирцийн бүртгэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ТУЗ-ийн 4 гишүүнд 8.6 сая төгрөгийн цалин, урамшуулал олгосон,
- Анхан шатны баримтын бүрдэлгүйгээр Туулын хишиг ОНӨААТҮГ-ын даргад 0.5 сая төгрөгийн урамшуулалт цалин тус тус олгосон.

2.4.8 Аудитад хамрагдсан орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь 2019-2021 онуудад төлөвлөсөн орон тоо, цалингийн зардлын хүрээнд цалин, урамшуулал олгосон бол Туулын хишиг ОНӨААТҮГ нь төлөвлөсөн цалингийн зардлыг 6.8-14.8 хувиар буюу 6.1-12.5 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. / Дэлгэрэнгүйг хавсралт 4-т харуулав /

2.4.9 Сэлэнгэ цэнгэг ус ААТҮГ нь 2021 онд эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр цалин хөлсийг 23-90 хувиар /удирдах ажилтны цалинг 0.6-0.9 сая төгрөгөөр, гүйцэтгэх ажилтны цалинг 0.2-0.4 сая төгрөгөөр, үйлчилгээний ажилтны цалинг 0.12-0.35 сая төгрөгөөр/ нэмэгдүүлснээс цалингийн зардлын гүйцэтгэл өмнөх оноос 117.1 сая төгрөгөөр өссөн байна.

2.4.10 Бусад орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын ажилтны дундаж цалин 0.6 саяас 0.8 сая төгрөг байгаа нь салбарын дундаж цалинтай /1.4 сая/

харьцуулахад 0.8 саяас 0.6 сая төгрөгөөр бага байгаа нь тогтвор суурьшилтай ажиллах мэргэжлийн боловсон хүчний дутагдал орох, үйлдвэрийн ашигт ажиллагаа буурах эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

2.4.11 Аудитад хамрагдсан орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд 2019-2021 онд хөрөнгө оруулалтын зардлыг 1,316.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 933.8 сая төгрөг зарцуулсан байна.

ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны хөрөнгө оруулалтын зардал

Хүснэгт №10

/сая төгрөг/

Д.д	ОНӨААТҮГ-ын нэр	2019 он			2020 он			2021 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	(-) Хэтрэлт, (+)хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	(-) Хэтрэлт, (+)хэмнэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	(-) Хэтрэлт, (+)хэмнэлт
1	Сэлэнгэ цэнгэг ус	29.0	29.9	(0.9)	-	14.3	(14.3)	96.4	147.4	(51.0)
2	Мандал Энержо	-	-	-	69.4	51.6	17.8	74.4	69.7	4.7
3	Сэлэнгэ Энержо	446.0	163.8	282.2	234.9	131.1	103.8	200.4	195.1	5.3
6	Цант-Орхон	59.1	59.1	-	56.8	45.2	11.6	50.6	26.6	24.0
	Нийт дүн	534.1	252.8	281.3	361.1	242.2	118.9	421.8	438.8	(17.0)

Эх сурвалж: ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны эдийн засгийн зорилтот түвшин

2.4.12 Хүснэгтээс харахад “Сэлэнгэ цэнгэг ус” ААТҮГ нь баталсан хөрөнгө оруулалтын зардлыг 2019 онд 0.9 сая төгрөгөөр, 2021 онд 50.9 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан бол бусад орон нутгийн аж ахуйн нэгжүүд нь эрх бүхий байгууллагаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсвийн хүрээнд зардал гаргасан байна.



•Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тавигдах хяналт шалгалт хангалтгүй байна.

3.1 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд ИТХ, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний дотоод аудитын нэгжээс тавих хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.

3.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1 -д иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь “ Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”-аар зохицуулагдсан байдаг.

3.1.2 Аймгийн ИТХ-аас 2019-2021 онуудад орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй ба Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын

газраас 2021 онд хийж гүйцэтгэсэн **“Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл, үйл ажиллагааны зохицуулалт, үр ашиг”** сэдэвт гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийн хүрээнд дээрх аж ахуйн нэгжүүдийн 2020-2021 оны үйл ажиллагааны тайланг ИТХТ-ийн хурлаар хэлэлцүүлсэн боловч үйл ажиллагааг үнэлж, дүгнэсэн болон цаашид авах арга хэмжээний талаар ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.

3.1.3 Аймаг, сумын ИТХ нь ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны тайланг сонсох төдий танилцаад өнгөрдөг бөгөөд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, засаглал, хяналтыг сайжруулах чиглэлээр бодлогын түвшний шийдвэрлэлт, хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.

3.1.4 ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын зүгээс дараах чиглэлээр хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх зүйн үндэслэл үйл ажиллагааны зохицуулалт, үр ашиг” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулах чиглэлээр аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт 3, Засаг дарга нарт 6, аймгийн ОНӨГ-ын даргад 3, ОНӨААТҮГ-ын удирдлагуудад 5 зөвлөмжийг тус бүр хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.
- 2021 онд аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу Гавшгай ус ХХК-ийн 2018-2020 оны үйл ажиллагаа, захирлын гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдал зэрэгт хяналт шалгалт хийж, түүний үр дүнгээр дарга, нягтлан бодогчдод сахилгын шийтгэл ногдуулах, санхүүгийн үйл ажиллагаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын хяналт шалгалт хийлгэхээр шийдвэрлэсэн боловч хэрэгжүүлээгүй байна.
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлөөс 2021 онд “Сэлэнгэ аймгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ, тулгамдсан асуудлууд”-ын хүрээнд “Урсгал ус” ХХК / тухайн үеийн нэршлээр /, “Гавшгай ус” ХХК, “Цант-Орхон” ХХК-уудын инженерийн шугам, сүлжээний насжилт, ундны усны эх үүсвэр, усны чанар, бохир ус цэвэрлэх байгууламжийн байдалд дүн шинжилгээ хийж, нийтийн аж ахуйн чиглэлээр анхаарч ажиллах асуудлуудыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.
- Эрчим хүчний зохицуулах хорооноос 2021 онд “Сэлэнгэ-энерго” ОНӨААТҮГ-ын дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын 2020-2021 оны зорилтын хэрэгжилтийг дүгнэх хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна. Хяналт шалгалтаар “Сэлэнгэ-энерго” ОНӨААТҮГ-ын 2020 оны зорилтын биелэлтийг “Дунд” гэж үнэлсэн бөгөөд цаашид авлага, өглөгийг бууруулж санхүүгийн зохистой харьцааг хангах, хэрэглэгчийн дуудлага, гомдол маргааныг шуурхай шийдвэрлэхэд программ хангамжийг нэвтрүүлэх болон 2021 оны зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмжийг өгсөн байна.

3.1.5 ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд төрийн байгууллагуудын зүгээс дараах чиглэлээр хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарт хугацаанд ОНӨААТҮГ-уудын жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийж гүйцэтгэсэн байна. Уг аудитаар 2019-2021 онуудад 9.9 сая төгрөгийн нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 1,303.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 546.1 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 40 зөвлөмжийг өгсөн байна.
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019 онд 3, 2020 онд 2, 2021 онд 1 үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд тус тус санхүүгийн хяналт шалгалт хийж, дүгнэлт зөвлөмж өгсөн байна. Хяналт шалгалтаар Шилэн дансны тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ыг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагааг хууль, журмын хүрээнд зохион байгуулах гэм мэт хэт ерөнхий зөвлөмж өгөгдсөн бөгөөд авлага, өр төлбөр, алдагдлыг бууруулах, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр дүн шинжилгээ хийгээгүй, хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.
- Аймгийн Татварын хэлтсээс “Гавшгай ус” ААТҮГ-ын 2018-2021 оны татвар ногдуулалт, төлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, татвар ногдох орлого, татварын хэмжээг дутуу тооцсон, ногдуулсан татварыг төлөөгүй зэрэг зөрчлүүдэд нөхөн татвар, торгууль, алданги тооцож 113.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон байна.
- Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2021 онд “Туулын хишиг” ОНӨААТҮГ-ын нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр 2 удаа албан шаардлага хүргүүлсэн байна.
- Аймгийн МХГ-аас нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлт, Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, 9 зөрчлийг арилгах албан шаардлага, 13 зөвлөмж өгсөн байна.

3.1.6 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд аймаг, сумдын ИТХ, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний дотоод аудитын нэгжээс тавих хяналт шалгалтын үр нөлөө муу, санхүүгийн шинжилгээ хийдэггүй, үйл ажиллагааны үр дүнг жил бүр үнэлж дүгнэдэггүй, хөндлөнгийн хяналт шалгалтаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлдэггүй зэргээс шалтгаалан ОНӨААТҮГ-ууд үйл ажиллагаа явуулах тусам зардал, авлага, өр төлбөр, алдагдал өсөх, улмаар цаашид одоо байгаа бүтэц, зохион байгуулалт, менежментээр өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжгүй байдалд хүрсэн байна.

3.2 ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын тогтолцоо бүрдэж, төлөвшөөгүй байна.

3.2.1 Аймгийн ИТХТ-ийн 2005 оны 78 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Урсгал ус”, “Цант-Орхон”, “Гавшгай ус” ХХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 1.1-д “ТУЗ нь хуулийн хүрээнд компанийн дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх, түүний хурлыг бэлтгэх, зохион байгуулах, шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавьж хариуцлага тооцох”-оор зохицуулагдсан байдаг.

3.2.2 Аудитын түүвэрт хамрагдсан орон нутгийн өмчит хуулийн этгээдээс 2019 оноос 2021 оны 7 дугаар сар хүртэл “Урсгал-Ус”, “Цант-Орхон”, “Гавшгай-Ус” ХХК-иуд / тухайн үеийн нэршилээр /-ийн ТУЗ-үүд тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:

- “Урсгал-Ус” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл 2019 онд 1, 2020 онд 1 удаа,
- “Цант-Орхон” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл 2019 онд 3, 2020 онд 1, 2021 онд 1 удаа,
- “Гавшгай-Ус” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл 2019 онд 3, 2020 онд 3, 2021 онд 2 удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэсэн байна.

3.2.3 ТУЗ-үүд ажиллах хугацаандаа компанийн тухайн жилийн үйл ажиллагааны болон орлого, зарлагын төлөвлөгөө батлах, үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, бүтэц, орон тоог шинэчлэх, цалин, урамшуулал, буцалтгүй тусламж олгох, техникийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах, хөрөнгийн хөдөлгөөнийг шийдвэрлэх зэрэг асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэж ирсэн байна.

3.2.4 Харин компанийн үйл ажиллагааны үр дүн, алдагдал, авлага, өр төлбөр жил бүр нэмэгдэж байгаа шалтгааныг тодорхойлох хяналт шалгалт хийгээгүй, цаашид өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл, боломж, менежментийг тодорхойлох үр нөлөө бүхий арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

3.2.5 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д, “ өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцах”-аар зохицуулсан байдаг.

3.2.6 Аудитын түүвэрт хамрагдсан ОНӨААТҮГ-уудаас Мандал Энерго, Цант-Орхон ОНӨААТҮГ-ууд дотоод хяналт хариуцсан ажилтныг томилсон боловч хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.

3.2.7 Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ-ын захирлын 2021 оны А/26 дугаар тушаалаар дотоод хяналт шалгалтын комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан боловч хяналт шалгалт огт хийгдээгүй байна.

3.2.8 Харин “Сэлэнгэ цэнгэг ус”, “Гавшгай ус”, “Туулын хишиг ОНӨААТҮГ- ууд нь дотоод хяналт хариуцсан ажилтан, нэгжийг томилж, ажиллуулаагүй байна.

Дээрх байдлаас үндэслэн ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын тогтолцоо бүрдэж, төлөвшөөгүй байна гэж дүгнэж байна.

3.3 ОНӨААТҮГ-ууд нь санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим санд холбогдох хугацаанд нь ил тод мэдээлэхгүй байна.

3.3.1 Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д мэдээллийн ил тод байдлыг “үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, төсөв, санхүүгийн ил тод байдал, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал “ гэсэн төрөлтэй байхаар заажээ.

3.3.2 ОНӨААТҮГ-ууд нь төсөв санхүүгийн ил тод байдал болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдалтай холбогдох харилцааг Шилэн дансны тухай хуулиар зохицуулж байна.

3.3.3 ОНӨААТҮГ-ууд нь мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар дараах арга хэмжээг, авч, хэрэгжүүлж байна. Үүнд:

- Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээг facebook цахим хуудсаар олон нийтэд хүргэж байна.
- Санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг шилэн дансны цахим хуудсаар мэдээлж байна.
- Ил тод байдлын самбарт үйл ажиллагааны мэдээллийг байршуулах гэх мэт.

3.3.4 Гэвч зарим орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын ил тод байдлын хангах үйл ажиллагаанд дараах зөрчлүүд оршиж байна. Үүнд:

- Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд дутуу, хугацаа хоцроож мэдээлдэг. Тухайлбал 2021 онд:
 - Сэлэнгэ Энержи ОНӨААТҮГ 3 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг огт мэдээлээгүй,
 - Мандал Энержи ОНӨААТҮГ 6 мэдээллийг хугацаа хоцроосон,
 - Туулын хишиг ОНӨААТҮГ нь 24 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээллийг огт мэдээлээгүй,
 - Гавшгай ус ААТҮГ нь 99 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээллийг огт мэдээлээгүй,
 - Сэлэнгэ цэнгэг ус ААТҮГ 38 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг огт мэдээлээгүй,
 - Цант-Орхон ААТҮГ 24 мэдээллийг хугацаа хоцроож, 10 мэдээллийг огт мэдээлээгүй гэх мэт.
- ТУЗ ажиллаж байх хугацаандаа компанийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч, хэрэгжилтийг хянах үүргээ хэрэгжүүлээгүй,
- Байгууллагын facebook цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэх мэдээлэл нь зарын шинж чанартай бөгөөд холбогдох хуульд заасан шаардлагыг хангахгүй байх,
- ОНӨААТҮГ-ын удирдлагууд аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээ болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгадаггүй гэх мэт.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар илэрсэн нийт **754.7** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Сэлэнгэ энерго ОНӨААТҮГ 125.8 сая төгрөгийн нүүрс, Сэлэнгэ цэнгэг ус ОНӨААТҮГ нь 72.0 сая төгрөгийн шатахуун, 76.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, Туулын хишиг ОНӨААТҮГ нь 2021 онд нүүрс тээвэрлэх үйлчилгээ 42.5 сая төгрөг зэрэг нийт **316.9** сая төгрөгийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээр шууд худалдан авалт хийсэн.
- **Гавшгай ус** ААТҮГ нь бараа материалын үлдэгдлээр тайлагнагдсан **40.9** сая төгрөгийн өртөг бүхий насос, хөдөлгүүр нь хүчин чадал тохирохгүйгээс ашиглах боломжгүй болсон.
- **Сэлэнгэ цэнгэг ус** ААТҮГ нь ХЧТА болон жирэмсэн, амаржсаны тэтгэмжийн тооцоог НДХ-ээр хянаж баталгаажуулаагүй байхад авлага үүсгэж, бүртгэсэн 5.6 сая төгрөг, албан байгууллагаас авах 92.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, айл өрхөөс авахаар тайлагнасан 26.9 сая төгрөгийн хариуцагч тодорхой бус, холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр цалин хөлсийг 23.0-90.0 хувиар нэмэгдүүлж, 117.1 сая төгрөг олгосон, баталсан хөрөнгө оруулалтын зардлыг хэтрүүлэн зарцуулсан 51.8 сая төгрөг зэрэг нийт **294.1** сая төгрөг.
- **Туулын хишиг** ОНӨААТҮГ нь агуулахын бүртгэл хөтлөөгүй, өдөрт зарцуулах норм, нормативыг тогтоогоогүй шаардах хуудас бичсэн болон хянасан албан тушаалтны гарын үсэггүй буюу анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нүүрс олгосон 35.8 сая төгрөг, төсвийн байгууллагаас авах авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 38.2 сая төгрөг, 2021 онд ажил гүйцэтгэх гэрээг дүгнээгүй, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нүүрс тээвэрлэх ажлын хөлсөнд 16.8 сая төгрөг олгосон, анхан шатны баримтын бүрдэлгүйгээр үйлдвэрийн газрын даргад 0.5 сая төгрөгийн урамшуулалт цалин олгосон зэрэг нийт **91.3** сая төгрөг.
- **Цант Орхон** ААТҮГ нь ХХОАТ чөлөөлөгдөх орлогоос буюу хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын цалингаас 2.9 сая төгрөг ХХОАТ суутгасан, хуралд оролцсон хурлын тэмдэглэл, ирцийн бүртгэл зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр ТУЗ-ийн 4 гишүүнд 8.6 сая төгрөгийн цалин, урамшуулал олгосон зэрэг нийт **11.5** сая төгрөг.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ОНӨААТҮГ-ын оролцогч талуудын зохистой харьцааг тогтоосон эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.
- Аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт компани /ОНӨААТҮГ/-ийн засаглалыг хөгжүүлэх, сайжруулах чиглэлээр үр нөлөө бүхий арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлээгүй байна.
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд зорилтот түвшинг байгууллагын 3 жилийн хэтийн зорилттой уялдуулж төлөвлөөгүй, аймгийн ОНӨГ-аар хянуулж, дүгнэлт гаргуулаагүй байна.
- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 2019-2021 онуудын орлогын төлөвлөгөө 90.9-110.9 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.
- Аудитад хамрагдсан ОНӨААТҮГ-ууд нь үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээхээр зорилтот түвшинг тодорхойлсон бөгөөд 66.7 хувь нь 2021 онд 1,376.9 сая төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.
- Дулаан үйлдвэрлэх, дамжуулах, усан хангамж, ариутгах татуургын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрийн газрууд нь өнөөгийн бүтэц, зохион байгуулалтаар бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөл, боломжгүй байдалд хүрсэн байна.
- Дийлэнх ОНӨААТҮГ-ууд нь удирдлагын зардлыг бодитоор төлөвлөхгүй байна.
- ОНӨААТҮГ-уудын үйл ажиллагаанд ИТХ, төсвийн ерөнхийлөн захирагч, түүний дотоод аудитын нэгжээс тавих хяналт шалгалтын үр нөлөө хангалтгүй байна.
- ОНӨААТҮГ-уудын гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын тогтолцоо бүрдэж, төлөвшөөгүй байна.
- ОНӨААТҮГ-ууд нь санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим санд холбогдох хугацаанд нь ил тод мэдээлэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Б.Нарантуяа-д:

- Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд хяналт тавих, бүтэц, зохион байгуулалт, менежментийн талаар бодлого боловсруулж, аймаг, сумдын Засаг дарга нар болон үйлдвэрийн газрын удирдлагуудад үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтийг хангуулах.
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт компани / ОНӨААТҮГ/-ийн засаглалыг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан арга хэмжээг хангуулах, хэрэгжилтэд нь хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх.
- Ашигт малтмалын хайгуулын болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, орон нутгийн өмчийн оролцоотой Сэлэнгэ байгалийн нөөц болон бусад ХХК-ийн орон нутгийн өмчийн төлөөлөгчийг нөхөн томилж, үйл ажиллагааг эрчимжүүлэх.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж болон сумдын Засаг дарга нарт:

- ЗГ-ын болон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт компани / ОНӨААТҮГ /-ийн засаглалыг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх.
- Аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, дүгнүүлдэг ОНӨААТҮГ-уудын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд бүтэц, зохион байгуулалт, менежментийн эрс өөрчлөлт хийж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг хангуулах арга хэмжээ авах.
- Аймгийн ОНӨГ болон төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын нэгж болох Санхүүгийн хяналт аудитын албаны компани /ОНӨААТҮГ/-ийн засаглалтай холбогдох чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ авах, хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөх.
- Эрчим хүчний зохицуулах хорооноос 2020 онд баталсан дулааны үнэ тарифыг мөрдөх, шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусган, батлуулах.

Аймгийн ОНӨГ-ын дарга П.Эрдэнэсайхан-д:

- Компани /ОНӨААТҮГ/-ийн засаглалтай холбогдох чиг үүргийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх, ОНӨААТҮГ-уудын 3 жилийн хэтийн зорилт, төлөвлөгөөг хянаж, нэгтгэн холбогдох байгууллагад хугацаанд нь хүргэж байх.
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаа, ашиг алдагдал, авлага, өр төлбөрт санхүүгийн шинжилгээ хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах.

ОНӨААТҮГ-ын дарга, удирдлагуудад:

- Жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор 3 жилийн хэтийн зорилт, үйл ажиллагааны төрөл, хамрах хүрээ, санхүүгийн төлөв, төлөвлөж байгаа ашиг, төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг, төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт зэргийг тусгасан зорилтын саналын төслийг аймгийн ОНӨГ-т хүргүүлж байх.
- Санхүүгийн үйл ажиллагаанд шинжилгээ хийж, эрсдэлийг үнэн зөв тодорхойлон, үр нөлөөг үнэлж дүгнэх замаар авлага, өр төлбөрийг барагдуулах, зардал бууруулах, үйлдвэрлэлийн үр дүнгээр өөрийгөө санхүүжүүлэн ажиллах нөхцөл боломжийг судлан, хэрэгжүүлэх.
- Үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагын дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх арга хэмжээ авч, үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах.
- Үндсэн болон санхүүгийн ил тод байдлыг хангах, шилэн дансны цахим санд холбогдох мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АХЛАХ АУДИТОР

С.БААСАНСҮРЭН

Ц. ОТГОНБАЯР

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: 7036-2223

2022.07.01 № 01/865
танай _____-ны № _____

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн
оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр
ашиг гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Тайлангийн төслийн дүн, дүгнэлт, зөвлөмжтэй
санал нийлж байна.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Ж.САЙНЦОГ

C:\user\albanbichig2022\jijig tootA5



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР**


213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: 7036-2127, 7036-3597

2022.06.30 № 294
танай _____-ны № _____

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн
оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр
дүн” сэдэвт аудитын төсөлтэй танилцлаа.
Холбогдох санал байхгүй болно.

ДАРГА




П.ЭРДЭНЭСАЙХАН

ОНӨААТҮГ-уудын орлогын төлөвлөгөө гүйцэтгэл

Д.д	Байгууллагын нэр	Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Сэлэнгэ цэнгэг ус	Нийт борлуулалт	1,657.1	1,306.4	1,953.7	1,339.7	2,647.3	2,468.4
		Үндсэн орлого	1,657.1	1,284.7	1,953.7	1,318.0	2,625.6	2,446.7
		Бусад орлого	-	21.7	-	21.7	21.7	21.7
2	Мандал энерго	Нийт борлуулалт	967.6	852.4	908.5	820.6	930.9	1,000.4
		Үндсэн орлого	924.4	781.6	796.4	816.7	814.4	992.5
		Бусад орлого	43.1	70.8	112.1	3.9	116.5	7.9
3	Сэлэнгэ Энерго	Нийт борлуулалт	5,786.4	5,344.9	5,721.9	5,685.1	5,844.4	6,869.8
		Үндсэн орлого	5,136.4	4,809.4	5,193.4	5,236.6	5,354.1	6,135.9
		Бусад орлого	650.0	535.5	528.5	448.5	490.3	733.9
4	Туулын хишиг	Нийт борлуулалт	239.8	208.7	276.4	222.7	281.5	387.3
		Үндсэн орлого	239.8	208.7	276.4	222.7	281.5	387.3
		Бусад орлого	-	-	-	-	-	-
5	Гавшгай-Ус	Нийт борлуулалт	1,590.8	1,518.9	1,223.8	1,548.8	1,266.2	1,441.2
		Үндсэн орлого	1,585.8	1,511.4	1,219.5	1,542.5	1,259.2	1,426.8
		Бусад орлого	5.0	7.5	4.3	6.3	7.0	14.4
6	Цант Орхон	Нийт борлуулалт	729.8	746.3	851.9	825.8	826.6	912.3
		Үндсэн орлого	724.0	722.9	841.9	816.8	816.6	904.2
		Бусад орлого	5.8	23.4	10.0	9.0	10.0	8.1
	Нийт дүн	Нийт борлуулалт	10,971.5	9,977.6	10,936.2	10,442.7	11,796.9	13,079.4
		Үндсэн орлого	10,267.5	9,318.7	10,281.3	9,953.3	11,151.4	12,293.4
		Бусад орлого	703.9	658.9	654.9	489.4	645.5	786.0
	Хэрэгжилтийн хувь	Нийт борлуулалт		90.9		95.5		110.9
		Үндсэн орлого		90.8		96.8		110.2
		Бусад орлого		93.6		74.7		121.8

ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны гол зардлуудын үнийн судалгаа



Хавсралт 3

ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Д/д	Санхүүгийн тайлангийн аудит хамарсан он	Байгууллагын нэр	Цалин, нэмэгдэл, урамшил, тэтгэмжийг алдаатай тооцоолсон, тушаал шийдвэргүйгээ давхардуулан олгосон	Худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, журам зөрчсөн	Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэсэн	Цалин, урамшууллыг нийгмийн даатгал, татварын тайланд зөрүүтэй тайлагнасан	Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуул аагүй, дутуу тусгасан	Бариа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээслэсгүй	Холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй гээр зээл авсан	Үйлдвэрлэлд тухай бүр ашиглагдахгүй бараа материалыг жил бүр их хэмжээгээр худалдан авч нөөцлөн, хөрөнгийн эргэлтийг удаашруулсан	Бусад хандив өгсөн
1	2019	Гавшгай ус	-	249.3	7.5	-	-	-	-	-	0.3
	2020		0.5	51.9	-	-	-	-	15.4	-	-
	2021		1.3	90.6	-	-	-	70.8	-	-	-
2	2019	Мандал энэрго	0.1	71.3	-	-	-	-	-	-	-
	2020		1.1	15.0	0.6	-	1.6	-	-	-	-
	2021		-	-	-	2.4	-	87.8	-	-	-
3	2019	Сэлэнгэ цэнгэг ус	5.0	67.3	-	-	-	-	-	-	-
	2020		0.6	48.4	-	0.8	-	-	-	-	-
	2021		2.2	14.8	-	-	-	62.4	-	-	-
4	2019	Сэлэнгэ энэрго	-	66.8	-	-	206.2	-	-	10.0	-
	2020		-	178.9	10.0	8.4	-	-	-	-	-
	2021		0.3	41.8	-	-	41.4	-	-	-	-
5	2019	Туулын хийшиг	-	35.7	-	-	30.8	-	-	-	-
	2020		1.4	80.7	2.4	-	-	-	-	-	-
	2021		-	63.0	-	-	-	-	-	-	-
6	2019	Цант Орхон	0.8	-	1.1	-	-	-	-	-	-
	2020		0.3	-	-	4.8	3.3	-	-	-	-
	2021		-	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн			13.8	1,075.5	21.6	16.5	283.3	221.0	15.4	10.0	0.3

Хавсралт 4

сая төгрөг

ОНӨААТҮГ-уудын 2019-2021 оны орон тоо, цалингийн зардлын судалгаа

Д.д	Байгууллагын нэр	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Үийцэтгэл	Үийцэтгэлийн хувь	Төлөвлөгөө	Үийцэтгэл	Үийцэтгэлийн хувь	Төлөвлөгөө	Үийцэтгэл	Үийцэтгэлийн хувь
1	Сэлэнгэ цэнгэг ус	Ажиллагсадын тоо	138.0	103.0	74.6	138.0	82.0	59.4	138.0	80.0	58.0
		Цалингийн сан	737.6	729.4	98.9	785.8	698.4	88.9	804.1	815.8	101.5
		Нэг ажилтны дундаж цалин	5.3	7.1	132.5	5.7	8.5	149.6	5.8	10.2	175.0
2	Мандал энерго	Ажиллагсадын тоо	40.0	40.0	100.0	38.0	38.0	100.0	39.0	38.0	97.4
		Цалингийн сан	246.4	224.5	91.1	304.9	289.6	95.0	313.7	304.5	97.1
		Нэг ажилтны дундаж цалин	6.2	5.6	91.1	8.0	7.6	95.0	8.0	8.0	99.6
3	Сэлэнгэ Энержо	Ажиллагсадын тоо	151.0	162.0	107.3	171.0	164.0	95.9	176.0	168.0	95.5
		Цалингийн сан	1,717.6	1,533.7	89.3	2,052.3	2,221.5	108.2	2,521.3	2,031.4	80.6
		Нэг ажилтны дундаж цалин	11.4	9.5	83.2	12.0	13.5	112.9	14.3	12.1	84.4
4	Туулын хишиг	Ажиллагсадын тоо	16.0	14.0	87.5	16.0	14.0	87.5	15.0	15.0	100.0
		Цалингийн сан	84.2	96.7	114.8	89.1	95.2	106.8	89.7	102.2	113.9
		Нэг ажилтны дундаж цалин	5.3	6.9	131.3	5.6	6.8	122.1	6.0	6.8	113.9
5	Гавшгай-Ус	Ажиллагсадын тоо	97.0	96.0	99.0	97.0	96.0	99.0	86.0	82.0	95.3
		Цалингийн сан	680.5	585.3	86.0	674.4	628.5	93.2	646.6	633.1	97.9
		Нэг ажилтны дундаж цалин	7.0	6.1	86.9	7.0	6.5	94.2	7.5	7.7	102.7
6	Цант-Орхон	Ажиллагсадын тоо	45.0	47.0	104.4	47.0	46.0	97.9	47.0	49.0	104.3
		Цалингийн сан	335.8	365.9	109.0	366.4	363.4	99.2	382.9	400.7	104.6
		Нэг ажилтны дундаж цалин	7.5	7.8	104.3	7.8	7.9	101.3	8.1	8.2	100.4
		Ажиллагсадын тоо	487.0	462.0	94.9	507.0	440.0	86.8	501.0	432.0	86.2
		Цалингийн сан	3,802.1	3,535.5	93.0	4,272.9	4,296.6	100.6	4,758.3	4,287.7	90.1
		Нэг ажилтны дундаж цалин	7.8	7.7	98.0	8.4	9.8	115.9	9.5	9.9	104.5
	Нэг ажилтанд ногдох дундаж цалин / сар /		0.7	0.6		0.7	0.8		0.8	0.8	